



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 492

Улаанбаатар хот

Б.Ерөөлтийг ажлаас чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1 дэх хэсэг, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 5.2.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 01/3488 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ерөөлтийг үүрэгт ажлаас 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосугай.

2. Б.Ерөөлтөд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч Р.Оюунбатад даалгасугай.

3. Б.Ерөөлттэй холбогдох тооцоо хийж, ажил хүлээлцэхийг Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ